



Pymetrics: Мэдээлэл болон өгөгдлийг ашиглан Авьяас, үр чадварын удирдлагад өөрчлөлт авч ирнэ

Уг технологи нь компаниуд илүү сайн ажиллах хүчнийг сонгон шалгаруулж авах боломжийг олгох зорилгоор шинжлэх ухааны үндэслэл бүхий хоёр сайжруулалтыг санал болгосон. Эдгээр нь:

- 1) неврологийн үнэлгээ
- 2) өгөгдлийн шинжлэх ухааны анализ, алгоритм юм.


Системээр дамжсан технологийн дэвшил

1. Неврологийн үнэлгээ

Pymetrics тоглоомууд нь мэдрэлийн систем судлалаас үүсэлтэй. Энд тухайн оролцогчийн танин мэдэхүй, нийгмийн оролцоо болон зан чанарыг үнэлэхийн тулд тэдний зан байдлыг ашигладаг. Энэхүү зан үйлд суурилсан үнэлгээ нь ихэвчлэн хувь хүн өөрийгөө үнэлэх үнэлгээг орлодог бөгөөд орчин үеийн чиг хандлага нь хүн өөрийгөө үнэлэхээс илүүтэйгээр өргөн хүрээтэй судалгааны арга хэрэгсэл ашиглан тухайн хүний зан хандлагыг тодорхойлох явдал маш түгээмэл болж байна. Энэ нь тухайн үнэлгээг явуулж буй хүний санаатай болон санаандгүй байдлаар оролцогчдыг ялгаварлах, хувийн үнэлэмжээр хандах зэрэг өрөөсгөл хандлагыг арилгаж, бодитой үнэлгээ хийх боломжийг олгодог.

2. Өгөгдлийн шинжлэх ухааныг ашиглах техник

Мэдээллийн шинжлэх ухааны сонгодог арга зүйг өгөгдлийн шинжлэх ухаан орлох болсон. Энэхүү өгөгдөлд суурилсан арга нь нарийн төвөгтэй өгөгдлийн сантай харьцаж, тухайн өгөгдлийн шугаман бус хамаарал, дүр зургийг тодорхойлж ирээдүйн таамаглалыг илүү сайн харуулдаг. Энэ нь бидний амьдралд тулгарч байдаг олон төвөгтэй асуудлыг загварчлах илүү тохиромжтой арга хэрэгсэл юм.





Түгээмэл асуулт, хариулт:

1. Энэхүү тоглоом нь яг юуг үнэлээд байна вэ?

Тоглоом 50 гаруй ялгаатай шинж чанарыг үнэлдэг. Та үнэлгээгээ бүрэн хийж дууссаны дараа бид таны тайланг илгээх болно. Танд тоглоомоо сонирхолтойгоор тоглох боломжийг олгох үүднээс бид үүнийг одоо тодорхойлон хэлэх боломжгүй!

2. Тоглоомоо бүрэн дуусгах хүртэл ямар хугацаа шаардагдах вэ?

Тоглоомоо эхлээд бүрэн дуусгах хүртэл ойролцоогоор 25 минут шаардагдана.

3. Би тоглож байх үедээ тоглоомоо түр зогсоох боломжтой юу?

Тоглоомын үеэр тоглоомыг түр зогсоох боломжгүй, нэг тоглоомын үед таниас 1-3 минут шаардагдах тул та цагаа сайтар төлөвлөх хэрэгтэй.

4. Тоглоомыг зөвхөн нэг удаа суугаад дуусгах хэрэгтэй юу?

Үгүй. Та өөрийн боломжоор тоглох боломжтой. Тоглоом бүр 2-3 минутын хугацаатай бөгөөд та завсарлахаасаа өмнө тухайн тоглоомоо дуусгасан байх шаардлагатай.

5. Би буруу тоглочих шиг боллоо... Энэ нь миний тус компанид ажилд орох боломжоо алдахад хүргэх үү?

Бүү санаа зов! Энэ бол стандарт шалгалт эсвэл IQ тест биш. Энд ямар ч зөв, эсвэл буруу хариулт байхгүй. Энэ нь таны давуу талуудыг олж харах замаар таны ирээдүйн карьер, мэргэжлийн чин хандлагыг зураглах арга юм. Та тоглоомоо чимээгүй орчинд, тайван тоглож чадвал бүх зүйлс энгийн байх болно.

6. Би тоглоомын үр дүнг өөрчлөх зорилгоор дахин тоглох боломж байгаа юу?

Та тоглоомыг хэдэн ч удаа давтан тоглох боломжтой ч таны хамгийн эхний үзүүлсэн үр дүнг бид ашиглах болно. Тоглоомыг давтан тоглоход үр дүн тань тийм ч их өөрчлөгдөхгүй. Хэрэв өөрчлөлт орсон тохиолдолд, бид таны давтан тоглолтын үр дүнг дунджаар авах боломжгүйг анхаарна уу.

7. Та бүхэн яагаад энэ үнэлгээний аргыг ашиглах болсон бэ?

Эдгээр тоглоомууд нь хүмүүсийн мэдрэхүй, сэтгэл хөдлөл, нийгмийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх зорилгоор неврологийн салбарт олон арван жилийн туршид хэрэглэгдэж байна. Иймээс тоглоомууд олон жилийн туршид баталгаажсан, үр дүн нь үнэн зөв гэдгийг бид мэдсэний үндсэн дээр ашиглах болсон.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй [ЭНД](#) дарж танилцаана уу.

Танд тусламж хэрэгтэй бол бидэнтэй OTRecruitmentTeam@ot.mn цахим хаягаар холбогдоорой.